

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 4 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Г Зарим брокер, дилерийн компаниуд болон Г
төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагад авч
хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Сүүлийн дөрвөн улирлын хугацаанд дараалан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй болон мөнгөн хөрөнгийн гүйлгээг зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй байгаа талаар харилцагчдаас нь өргөдөл гомдол ирүүлсэн компаниудын төлбөрийн чадварт учирч болзошгүй хүндрэлийг даван туулах, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах зайлшгүй шаардлагатайг ТЭМДЭГЛЭН,

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Итгэмжлэлийн үндсэн дээр харилцагчийн захиалга үйлдэх, холболтын данс нээх, данс нэгтгэх, данс хооронд мөнгөн болон үнэт цаасны шилжүүлэг хийх, “ҮЦТТТХТ” ХХК-иас харилцагчдын бэлэн мөнгө хүлээн авах, өөрийн компаниар дамжуулан тараах үйл ажиллагааг хавсралтад нэр дурдсан брокер, дилерийн компаниудыг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээ хангах хүртэл түр зогсоосугай.

2. Энэхүү тогтоолын 1-д заасан үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан, харилцагчдын мөнгөн хөрөнгийг түүний арилжааны банкин дахь эзэмшлийн данс руу шилжүүлэх, эсхүл харилцагч өөрөө хүрэлцэн ирсэн нөхцөлд бэлнээр гаргаж өгөх бэлтгэл ажлыг 2010 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн дотор хангаж, уг үйлчилгээг шуурхай зохион байгуулж ажиллахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

3. Компанийн санхүүгийн чадавхийг сайжруулах, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 2010 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор бүрэн хангах төлөвлөгөөг шуурхай боловсруулж 2010 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан Хороонд ирүүлэх, улмаар уг төлөвлөгөөний биелэлтийг сар бүрийн эхний долоо хоногт багтан тус Хороонд тайлагнаж ажиллахыг хавсралтад нэр дурдсан брокер, дилерийн компанийн Хувь

нийлүүлэгчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын 1 болон 3-т заасан үүргийг биелүүлээгүй, тогтоосон хугацаанд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй брокер, дилерийн компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг хавсралтад нэр дурдсан брокер, дилерийн компанийн Хувь нийлүүлэгчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт анхааруулсугай.

5. Үйл ажиллагааны улмаас үүсч болох эрсдлийг бууруулах, хууль бус үйлдэл гарч болох нөхцлийг арилгаж, компанийн дотоод хяналтыг эрс нэмэгдүүлэх, баримтын бүрдэл, хадгалалтын горимоо чангатгах, харилцагчдын бэлэн мөнгө тараасан зарлагын тайланг “ҮЦГТТХТ” ХХК-тай 2010 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн дотор тооцоо нийлэн, актүйлдэхийг хавсралтад заасан брокер, дилерийн компанийн удирдлагад үүрэг болгосугай.

6. Харилцагчийн дансанд үнэт цаас, мөнгөн хөрөнгө хадгалах, түүнд гүйлгээ хийхтэй холбогдсон ажиллагаанд гарч буй эрсдэл болон зөрчилд дүгнэлт хийж данснаас үнэт цаас, мөнгөн хөрөнгийг гүйлгээнд оруулахын өмнө хадгалж буй байгууллага тухайн харилцагчаас тодруулга, зөвшөөрөл заавал авдаг байх горимд шилжих, кастодианы үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг 2010 оны 6 дугаар сард багтаан зохион байгуулахыг “ҮЦГТТХТ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Сүхбаатар/, Гүйцэтгэх захирал /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

7. Нийт брокер, дилерийн компанийн эрсдлийн санг тухайн компанийн “ҮЦГТТХТ” ХХК дахь дансанд байршуулдаг байх, уг сангийн хэмжээнд байнга хяналт тавьж ажилладаг байх горимыг 2010 оны 5 дугаар сард багтан нэвтрүүлэхийг “ҮЦГТТХТ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Сүхбаатар/, Гүйцэтгэх захирал /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

8. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Т.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН